



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД
АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

**УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨН
ХУВААРИЛЖ, БАТЛАГДСАН ТӨСВИЙН 99.09 ХУВИЙГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**АУДИТЫН КОД:
ОРА-2024/06-
ШТА-НА**

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088

Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805

Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл

Утас: 70357955

Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үг.....	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	2
Аудитын зорилт:	2
Аудитын хамарсан хүрээ:.....	3
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	3
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:.....	3
Үндсэн мэдээлэл.....	3
БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.	4
1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.	4
1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.....	5
1.3 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	6
БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙН 99.09 ХУВИЙГ АЙМАГ, СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	7
2.1 Батлагдсан төсвийн 0.91 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	7
2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	9
2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.	10
Дүгнэлт	10
Гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэр	10
Аудитын тайлан баталгаажуулах тушаал	12
Холбогдох байгууллагын санал	13

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МТБ	Мэдээлэл технологийн баг
СНЖ	Сонгогчдын нэрийн жагсаалт
СХ	Сонгуулийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Зардлын гүйцэтгэл	4
2	Сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт	6
3	УБХ, Цагдаагийн газарт олгосон санхүүжилт	6
4	Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт	7
5	Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан	9

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Сонгуульд ажилласан албан хаагчид	4
2	СЕХ-с олгосон санхүүжилт	5
3	УБХ-ийн зардлын зарцуулалт	8

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын сонгуулийн хороод, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Орхон аймаг дахь Цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлж, аудитор Ц.Одгэрэл, Ж.Наранчимэг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 4 дүгээр тойрогт Орхон аймгийн сонгуулийн хороонд 11 ажилтан, 2 сумын сонгуулийн хороонд 14 ажилтан, сонгуулийн 48 хэсгийн хороонд 432 ажилтан, 5 мэдээлэл технологийн ажилтан, 48 даамал, 5 нөөц даамал, 51 улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 186 албан хаагч, нийт 566 албан хаагч ажилласан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210022001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Сонгуулийн хорооны дарга Ш.Ганболд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Энхжаргал хариуцан гүйцэтгэжээ.

Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210122001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны дарга Ш.Өлзийбаяр, 2 дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны гишүүн Б.Ган-Эрдэнэ нар хариуцан гүйцэтгэсэн бөгөөд Жаргалант сумын Төрийн сангийн 100210222001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Жаргалант сумын сонгуулийн хорооны дарга Т.Энхжаргал, 2 дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны гишүүн Н.Мядагмаа нар тус тус гүйцэтгэсэн байна.

Дүрслэл 1. Сонгуульд ажилласан албан хаагчид

/хувиар/



Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Орхон аймгийн сонгуулийн хорооны төсөвт 448,509.0 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн төсөвт 57,128.9 мянган төгрөг, Цагдаагийн газрын төсөвт 27,300.0 мянган төгрөг тус тус баталсан байна.

БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Орхон аймаг буюу Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 4 дүгээр тойрогт ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 3 байгууллагад 533,196.6 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан ирж гүйцэтгэлээр 531,429.4 мянган төгрөгийг зарцуулж 1,767.3 мянган төгрөгийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 1. Зардлын гүйцэтгэл


/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Орхон аймгийн сонгуулийн хороо	448,509.00	447,000.40	1,508.60
2	Улсын бүртгэлийн хэлтэс	57,387.60	57,128.95	258.65
3	Цагдаагийн газар	27,300.00	27,300.00	-
	Дүн	533,196.60	531,429.35	1,767.25

СЕХ-с Орхон аймгийн сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ төсвийн хуваарь, хуваарилсан төсвийн тайлбар, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

СЕХ-ноос Орхон аймгийн сонгуулийн хороонд СХ-ны гишүүдийн урамшуулал, НДШ, хоолны зардалд 342,990.0 мянган төгрөг, маягт хэвлүүлэх, шуудан холбоо, бичиг хэргийн зардалд 15,960.0 мянган төгрөг, томилолт, сургалт, сурталчилгаа, унааны зардалд 87,255.0 мянган төгрөг, болзошгүй зардалд 2,304.0 мянган төгрөг, нийт 448,509.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дүрслэл 2. СЕХ-с олгосон санхүүжилт /төгрөгөөр/



СЕХ-ноос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, хэсгийн хороод, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан тооцож, хэрэгцээ шаардлагыг үндэслэн зардлыг бодитой тооцоолсон байна.

1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Орхон аймгийн сонгуулийн хороо нь 2 сумын сонгуулийн хороотой бөгөөд Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 45 хэсгийн хороо, Жаргалант сумын хэсгийн хороонд 3 хэсгийн хороо байгуулагдан ажилласан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооноос Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 332,451.0 мянган төгрөг, Жаргалант сумын сонгуулийн хороонд 27,273.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

Хүснэгт 2. Сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Баян-Өндөр сумын Сонгуулийн хороо	Жаргалант сумын Сонгуулийн хороо	ДҮН
1	Бичиг хэрэг	5,600.00	560.00	6,160.00
2	Шуудан холбоо	6,900.00	600.00	7,500.00
3	Унаа	26,140.00	2,200.00	28,340.00
4	Санал авах байр бэлтгэх	17,235.00	1,149.00	18,384.00
5	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	253,792.00	20,944.00	274,736.00
6	Хоолны зардал	20,600.00	1,700.00	22,300.00
7	Болзошгүй зардал	2,184.00	120.00	2,304.00
	Нийт дүн	332,451.00	27,273.00	359,724.00

Орхон аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг тооцохдоо сумдын хүн амын тоо, хэсгийн хороодын байршил зэргийг харгалзан үзэж хуваарилсан байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хэсгийн хороодын унааны зардлыг хуваарилахдаа хэсгийн хороодын байршлыг харгалзан үзсэн бол бусад зардлыг СЕХ-с баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу хуваарилсан байна.

1.3 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжих зардлыг УБЕГ-ын төсөвт 3,039,033.8 мянган төгрөг, ЦЕГ-ын төсөвт 1,460,075.3 мянган төгрөг тус тус баталснаас Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 57,387.6 мянган төгрөг, Цагдаагийн газарт 27,300.0 мянган төгрөг тус тус хуваарилагдсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийг хуваарилахдаа хэсгийн хорооны тоо, сонгуулиар ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны тоо зэргийг харгалзан үзсэн бол Цагдаагийн газрын төсвийг сонгуульд ажиллах нийт бие бүрэлдэхүүний тоонд үндэслэн хуваарилсан байна.

Батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 3. УБХ, Цагдаагийн газарт олгосон санхүүжилт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Улсын бүртгэлийн хэлтэс	Цагдаагийн газар	ДҮН
1	Бичиг хэрэг	2,744.60	-	2,744.60
2	Шуудан холбоо	-	7,420.00	7,420.00
3	Унаа /Шатахуун/	862.00	2,000.00	2,862.00
4	Хоолны зардал	-	17,880.00	17,880.00
5	Сургалт зохион байгуулах	6,328.90	-	6,328.90
6	Сургалтын бусад зардал	1,040.00	-	1,040.00
7	Сургагч багш нарын зардал	979.00	-	979.00
8	Шуурхай багийн зардал	2,672.10	-	2,672.10
9	Техник хэрэгсэл тээвэрлэх тээврийн хөлс	4,400.00	-	4,400.00
10	Шуурхай баг, нөөцийн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	38,361.00	-	38,361.00
	Нийт дүн	57,387.60	27,300.00	84,687.60

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙН 99.09 ХУВИЙГ АЙМАГ, СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 Батлагдсан төсвийн 0.91 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Орхон аймгийн сонгуулийн хороо нь 448,509.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 332,451.0 мянган төгрөгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд, 27,273.0 мянган төгрөгийг Жаргалант сумын сонгуулийн хороонд тус тус хуваарилж, 87,276.4 мянган төгрөгийг зарцуулж 1,508.6 мянган төгрөгийн хэмнэлтийг СЕХ-ны дансанд төвлөрүүлсэн байна. Хэмнэлт үүссэн шалтгаан нь Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-д буцаан хүлээлгэн өгөх зардлаас 1,320.0 мянган төгрөг, МТБ, даамлын сургалтын зардлаас 3.8 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 69.8 мянган төгрөг, томилолтын зардлаас 115.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

Баян-Өндөр болон Жаргалант сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсвөөс хэмнэлт үүсээгүй бөгөөд хуваарилсан төсвийг бүрэн зарцуулсан байна. Зарцуулалтыг зардлын зүйл бүрээр дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Аймгийн СХ	Баян-Өндөр сумын СХ	Жаргалант сумын СХ	ДҮН
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.00	-	-	300.00
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2,490.00	-	-	2,490.00
3	МТБ, даамлын сургалт	2,646.20	-	-	2,646.20
4	Бичиг хэрэг	1,000.00	5,600.00	560.00	7,160.00
5	Шуудан холбоо	930.20	6,900.00	600.00	8,430.20
6	Унаа	2,690.00	26,140.00	2,200.00	31,030.00
7	Санал авах байр бэлтгэх	2,496.00	17,235.00	1,149.00	20,880.00
8	Сурталчилгааны зардал	8,000.00	-	-	8,000.00
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ буцаан хүлээлгэн өгөх	15,920.00	-	-	15,920.00
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах, унааны зардал	1,300.00	-	-	1,300.00
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	6,776.00	253,792.00	20,944.00	281,512.00
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	35,728.00	-	-	35,728.00
13	Хоолны зардал	3,450.00	20,600.00	1,700.00	25,750.00
14	Томилолтын зардал	2,230.00	-	-	2,230.00
15	Шуурхай багийн зардал	1,320.00	-	-	1,320.00
16	Болзошгүй зардал	-	2,184.00	120.00	2,304.00
17	СЕХ-нд төвлөрүүлэлт	1,508.60	-	-	1,508.00
	Нийт дүн	88,785.00	332,451.00	27,273.00	447,000.40

Сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор УБЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” А/24 дугаартай тушаалаар Орхон аймгийн УБХ-т 57,387.6 мянган төгрөг хуваарилснаас 57,128.9 мянган төгрөгийг зарцуулан 258.7 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Зардлын зарцуулалтыг дүрслэлээр харуулав.

Дүрслэл 3. УБХ-ийн зардлын зарцуулалт

/мянган төгрөгөөр/



ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 16/1983 дугаартай албан бичгээр ирүүлсэн “УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсөв”-ийн дагуу хуваарилсан 27,300.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Цагдаагийн газар 17,880.0 мянган төгрөгийг хоолны зардалд, 7,420.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд, 2,000.0 мянган төгрөгийг шатахууны зардалд тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга, гишүүнд тус бүр 117.6 мянган төгрөгийн, нийт 235.2 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.6-д “Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна” гэж заасныг зөрчсөн байна.
- Орхон аймгийн сонгуулийн хороо нь томилолтоор ажилласан мэдээлэл, технологийн багийн 5 албан хаагчид анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, алдаатай баримтаар 1000.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан

- шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.
- Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, алдаатай баримтаар 354.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.
 - Ачаа тээвэрлэлтийн гэрээнээс 220.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгалгүй олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.2-д "үйл ажиллагааны орлого", 8.1.2-д "хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого" гэж заасантай нийцэхгүй байна.
 - Сонгууль зохион байгуулахтай холбоотой дээд шатны байгууллагаас хуваарилсан бичиг хэргийн зардлын төсвөөс 3,023.4 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороо нэгтгэн тайлагнасан байна.

Хүснэгт 5. Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.00	300.00	-	0.00%
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2,490.00	2,490.00	-	0.00%
3	МТБ, даамлын сургалт	2,650.00	2,646.20	3.80	0.25%
4	Бичиг хэрэг	7,160.00	7,160.00	-	0.00%
5	Шуудан холбоо	8,500.00	8,430.20	69.80	4.63%
6	Унаа	31,030.00	31,030.00	-	0.00%
7	Санал авах байр бэлтгэх	20,880.00	20,880.00	-	0.00%
8	Сурталчилгааны зардал	8,000.00	8,000.00	-	0.00%
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ буцаан хүлээлгэн өгөх	17,240.00	15,920.00	1,320.00	87.50%
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах, унааны зардал	1,300.00	1,300.00	-	0.00%
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	281,512.00	281,512.00	-	0.00%
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	35,728.00	35,728.00	-	0.00%

13	Хоолны зардал	25,750.00	25,750.00	-	0.00%
14	Томилолтын зардал	2,345.00	2,230.00	115.00	7.62%
15	Шуурхай багийн зардал	1,320.00	1,320.00	-	0.00%
16	Болзошгүй зардал	2,304.00	2,304.00	-	0.00%
	Нийт дүн	448,509.00	447,000.40	1,508.60	100.00%

2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийг СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна. Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг аймгийн сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч, сумдын сонгуулийн хорооны зарцуулалтыг сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа Төрийн санд нээлгэсэн сонгуулийн бүртгэлийн дансанд гарын үсгийн баталгаа гарган хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрын санхүүжилтийг тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн төвлөрүүлэн захирагчдын данснаас шилжүүлсэн бөгөөд зарцуулалтыг төсвийн шууд захирагч, ахлах нягтлан бодогчид 1, 2 дугаар гарын үсгийг зурж Төрийн сангийн хяналтад зарцуулагдсан байна.

Аудитын явцад сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын зарцуулалтын анхан шатны баримт материалтай танилцахад Орхон аймгийн сонгуулийн хороо нь болзошгүй зардлаас бусад зардлын тухайд СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу, бусад байгууллагын тухайд зарцуулалт хийхдээ дээд шатны төсвийн захирагчдаас ирүүлсэн тайлбар, чиглэлийн дагуу зарцуулсан байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй байна.
- Батлагдсан төсвийн 99.09 хувийг аймаг, сумдын сонгуулийн хороо болон бусад байгууллагууд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэр

ОРХОН АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА Ш.ГАНБОЛДОД

ЗӨВЛӨМЖ

1. Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулах.

БАЯН-ӨНДӨР СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА Ш.ӨЛЗИЙБАЯРТ

ТӨЛБӨРИЙН АКТ

1. Илүү олгосон урамшуулал 235.2 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ОТГОНБАЯРТ

ЗӨВЛӨМЖ

1. Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах.
2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллах.
3. Батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байх.

ТАЙЛАН БИЧСЭН: АУДИТОР



Ц.ОДГЭРЭЛ

Ж.НАРАНЧИМЭГ

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БУЯН-УНДРАХ

Аудитын тайлан баталгаажуулах тушаал



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/07

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайлан /ОРА-2024/06-ШТА-НА/-г баталгаажуулсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2024 оны 11 сарын 20-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Орхон аймгийн сонгуулийн хорооны дарга (Ш.Ганболд), Баян-өндөр сумын сонгуулийн хорооны дарга (Ш.Өлзийбаяр), Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (М.Отгонбаяр) нарт зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-өндөр сумын сонгуулийн хороо, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), аудитор (Ц.Одгэрэл) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

Холбогдох байгууллагын санал

ОРХОН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Захиргааны 2 дугаар байр, 2 дугаар баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025
Утас: 7035 8118, Факс: (976) 7035 8673,
Цахим шуудан: orkhon@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.orkhon.burtgel.gov.mn

2024.07.23 № 698

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТАД

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТАСГИЙН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ



Ө.ГАНЗОРИГ

Ө.ГАНЗОРИГ

У.Орзориг
Аудитагч
VII/23

6124000621



ОРХОН АЙМАГ
СОНГУУЛИЙН ХОРОО

Нутгийн удирдлагын ордон, Амарын талбай, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 99355775, 70353000

2024.07.23 № 35
танай 2024.07.23 -ны № 295 -т

Хариу хүргүүлэх тухай

Аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй. Өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

М.МӨНХБАЯР

